



Түүхийн баримтад түшиглэн товчоолсон том хэмжээний туурвилыг товчоо гэнэ. Товчоо зохиол нь түүхэн хэрэг явдал, түүхэн цаг хугацаагаар хязгаарлагдана.

«Монголын нууц товчоо»-нд монголчуудын уг гарлаас эхлээд Чингис хаан нас эцэслэж, Өгөдэй хаан ширээнд ор суусан үеийг өгүүлсэн байдаг. Нийт арван хоёр бүлэгтэй. Эхний арван бүлэг нь Чингис хааны /1162-1227/ нас эцэслэсний хойтон шар хулгана жил буюу 1228 онд, сүүлчийн хоёр бүлэг нь Өгөдэй хааныг /1186-1241/ нас барсны үед зохиогдоод, Тогоон Төмөр /1320-1370/ хаан 1368 онд Бээжингээс зугтан гарч, Юань төр мөхөх хүртэл маш нууц нандин шүтээн болон хадгалагдаж байгаад хожим галиглаж, орчуулж барлажээ.

«Монголын нууц товчоо» зохиол хооронд нь уран зохиомлоор холбосон 30 гаруй өгүүллэгээс бүтдэг бөгөөд тэр бүхэн нь монголчуудын түүхэнд үнэхээр болж өнгөрсөн хэрэг явдлын дүр зургийг нүдний өмнө тодруулж өгдөг цуврал зураг мэт бичигдсэн байдаг.

Хам сэдэв: Зохиолын дүрийг тодорхойлж буй тухайн цаг үеийн нийгэм-соёлын нөлөө, үйл явдал, үзэл бодол зэрэг нөхцөл байдлыг хэлнэ.



Үндэсний ижилсэл: Үндэстэн гэдэг бол хэл, газар нутаг, эдийн засаг, соёлын нийтлэг байдалтай ард түмэн юм. Үндэсний ижилсэл гэдгийг хялбар тодорхойлбол хүн өөрийгөө аль нэг улс, үндэстэнд хамааруулан ойлгох тэр мэдрэмж, шинж тэмдгийг хэлдэг ажээ. Тэнгэр ивээлээ, тэнгэр өршөөг, тэнгэртээ залбиръя гэж тэнгэрээ дээдэлдэг нь монголчууд. Хөх тэнгэр, хөх толбо, хөх бичиг, хөх толбо гэж ярьж ойлгодог нь мөн л манай монгол үндэстэн. Үүнийг л үндэсний ижилсэл гэж үздэг аж. Үндэсний ижилсэл нь бусад үндэстнээс ялгарах ялгарал болдог.

I

Сурагчийн овог нэр:
.....

Эхэлсэн....онсар.....өдөр.....цаг
Дууссан....онсар.....өдөр.....цаг

Сэдэв: Монголын нууц товчоо зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгох


Зорилго: Нийгэм ба соёлын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг задлан шинжлэх

Монголчууд эрт дээр цагаас ураг холбох ёсыг машид эрхэмлэж, ураг сонгох, удмаа таниулах, ургийн баяр хийх, угийн бичиг хөтлөх гэх зэргээр нийгмийн амьдралын нэгэн уламжлалт соёл, ёс заншлыг бий болгосон байна.

Дасгал 1. Соёлын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг тодорхойлоорой.

Угсаа гарваль, үүсэл гарал.

Алхам 1. Монголын нууц товчоо зохиолын гол дэвшүүлсэн утга бол Монголчуудын угсаа гарал нэг гэдгийг харуулж, сануулах билээ. Чингис хааны удам угийн бичгийг нөхөж бичээрэй.



Алхам 2. Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол болон Монголын нууц товчоо зохиолд Монголчуудын угсаа гарвацийг дэлгэрэнгүй бичсэний ач холбогдлыг эргэцүүлж бичээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

Та бүхэн өөрсдийн Угийн бичиг хөтлөөрэй. Ингэхдээ Монгол улсын Засгийн газрын 1997 оны 17 дугаар тогтоолоор баталсан “УГИЙН БИЧИГ ХӨТЛӨХ ЖУРАМ”-ыг уншиж, судлаарай.

Алхам 3. Монголын нууц товчоо зохиолын 40-р зүйлд “...Жажирадайн хөвүүн Тугудай нэрт бүлгээ. Тугудайн хөвүүн Бури-булчиру, Бури-булчиругийн хөвүүн Хар-хадаан бүлгээ. Хар-хадааны хөвүүн Жамуха бүлгээ...” гэж дүрсэлсэн байдаг. Тэд ямар овогтон бэ?

.....

Ургийн холбогдлоос овог бий болдог. Овог нь гарал үүсэл, хэл яриа, зан заншил, соёл, аж байдлын нийтлэг шинжтэй цусан төрлийн холбоо бүхий бүлэг юм. Эртний Монголчуудын дунд үндэсний ижилсэл бүхий хүмүүсийг нэг овог гэж хэлж байсан. Тухайлбал: Дэй Сэцэн “Манай хонгирад хэдийнээс бусдын нутаг ба хүнийг булаан тэмцэлддэггүй”, “Манай хонгирад хэдийнээс хацар гоо хатадтай, өнгө сайн охидтой тул зээгийн зүсээр, охидын өнгөөр явна” гэх зэргээс тодорхой харж болно.

Алхам 4. Дараах хүмүүс ямар ямар овогтон болсныг нөхөж бичнэ үү.

Бүгүнүтэй	Бэлгүнүтэй	Буха хатаги	Бухату салжи	Бодончар мунхаг

Ураг төрөл бололцох

Алхам 1.

Монголын нууц товчооны 65-р зүйлд “Нуган хүүхэд нутгаа эзэмшинэ. Охин хүүхэд өнгө шилэгдэнэ” гэж бичсэнг Эртний монголчуудын ураг барилцах ёс уламжлалтай холбон тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

Монголчуудын ахуй амьдрал болон нийгэм улс төрд ураг төрөл бололцох ёслол нэн чухал байр суурь эзэлдэг эртний түүхэн уламжлалтай билээ. Энэ нь эртний монголчуудын нутгаас олдож байгаа олдвор, хадны сүг зургаас харагддаг.

Алхам 2. “...Хамгийн хаан, улсын эзэн байтал охиноо өөрөө үдэж хүргэхийг надаар цээрлэл болгогтун!” (53-р зүйл)

Амбагай хааны энэхүү захиас үг монголчуудын ураг хуримын ямар ёс уламжлалтай холбогдож байна вэ?

.....
.....
.....

Алхам 3. Дараах хэсгүүдийн утгыг эртний монголчуудын ураг барилцах ёстой холбон тайлбарлаарай.

Есүхэй баатар Тэмүжинг хүргэж өгөв:

Энэ үед Тэмүжин 9, Бөртэ 10 настай байв:

.....
.....
.....

Болжигин овогтон

Боржигин гэдэг үгийн язгуур нь “бор, бүри, бөртэ” гэх мэт чоныг заасан үг, “жигин” гэдэг нь “тигин” хэмээх үгийн хувилбар, Боржигины дээдэс чоно онгонтой байсан тул ийнхүү нэрлэв гэж үздэг. Бас зарим бичигт бор буюу цэнхэр бор нүдтэй гэсэн үг хэмээн тайлбарласан байдаг. Боржигин овгийнхон 1000-аад жил монголын гол овог буюу ноёрхох овог байсан ба хүн ам олонтой байсан байна.

Алхам 1. Буха хатаги, Бухату салжи, Бодончар мунхаг гурав Добу мэргэнийг үгүй болсны хойно мэндэлсэн. Үүнийг Алун-гуа эх юу гэж тайлбарласан бэ? Мөн энэ нь ямар бэлгэдлийг агуулж байна вэ?

.....
.....
.....

“...Хар тэргүүт хүнтэй адилтгаж яахин болно. Хамгийн хаад болох цагт харц хүн сая учрыг мэднэ” (21-р зүйл)


Алхам 2. Бодончар мунхаг юуны учир урагт үл тооцогдсон бэ? Түүний учрыг тайлбарлаарай.

.....
.....

Алхам 3. Алун-гуа эхийн “Та таван хөвүүн, миний нэгэн хэвлээс төрсөн биш үү. Та нар ганц ганцаар салбал нэжээд сум мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв эеэ

нэгтгэвэл тэр багласан таван сум мэт бэх болж, хэнд ч хялбар дийлэгдэхгүй болно” гэсэн сургаалд тохирох зүйр үг олж бичээрэй.

Алхам 4. Бодончарын зан чанарыг тодруулж бичээрэй



Алхам 5. Бодончар мунхаг Бухату салжи ахдаа “Ах аа, ах аа, бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” хэмээн хэлсэн үгийн утгыг тайлбарлаарай.

Нийгэм түүхийн хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг тодорхойлъё.

Алхам 1. Монгол туулийн гол дүрийн баатар Ер бусын шинж үзүүлж төрдөг. Тэмүжин эхээс мэндлэхдээ ямар шинж үзүүлсэн бэ?

Эрийн сайн Хан Харангуй	Гэсэр	Тэмүүжин
...Газартай гацалцан төрсөн Тэнгэр нартай тэрсэлцэн төрсөн...	Баруун нүдээ хялайж, зүүн нүдээ харж баруун гараа далайж, зүүн гараа атгаж, баруун хөлөө дээш өргөж, зүүн хөлөө жийж, дөчин таван дун цагаан шүдээ зуусаар төрөв.	

Алхам 2. Чингис хаантай холбоо бүхий онуудыг зөв харгалзуулаарай.

- 1. Эхээс мэндлэв. А. 1206
- 2. Хаан өргөмжлөв. Б. 1227
- 3. Их Монгол улсыг нэгтгэн байгуулав. В. 1189
- 4. Тэнгирт халив. Г. 1162

Алхам 3. “...Есүхэй худ, охиныг үзвэл нүүртээ гэрэлтэй, нүдэндээ галтай охин тул санаанд нийлэв...”, “...Дэй сэцэн өгүүлрүүн: Энэ хөвүүн чинь нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй хөвүүн байна” хэсэгт Бөртэ болон Тэмүжинг тодорхойлохдоо хэрхэн дүрсэлсэн бэ? Ялгаатай зүйл байна уу?

.....

Алхам 4. Тэмүжин, Жамуха хоёр эвдрэлцсэний дараа Алтан, Хучар, Саяа бэхи, Даридай отчигин, Мулхалху нар Тэмүүжинг хаан, Багу чорхи /хатагин/, Чирхитэй баатар /салжиуд/, Хачиун бэхи /дөрвэн/, Алчи, Жалт Буха /татаар/, Түгэ маха, /ихирэс/, Тэрхэг Эмэл Алхуй /хонгирад/, Чоёг /горлос/, Хүчүгүд, Буйруг хан /найман/, Хуту /мэргид/, Худуга бэхи /ойрад/, Таргудай Хирилтуг /тайчууд/, Аучу баатар нар Жамухыг ханд өргөмжилжээ. Хаан цолыг хэзээ, хаана авсныг нөхөж бичээрэй. /121-123 болон 141-р зүйл

Нэр	Хааны нэр	Он	Хаана
Тэмүжин			
Жамуха			

Алхам 5. Тэмүжин Татар аймгаас өшөө авах болсон 2 шалтгааныг бичээрэй. 53 болон 67-68-р зүйлийг эргэж хараарай.

-
-

Алхам 6. Чингисийн 9-н өрлөгийг нэрлэнэ үү?

.....
.....	

Алхам 7. Монголын нууц товчоо зохиолын 12-р бүлэгт Өгөдэй хааны 4 сайн ба 4 муу үйлийг дурдсан байдаг. Түүнийг нөхөж бичнэ үү.

Сайн үйл	Муу үйл
	Улсын эзэн хаан байтал, ёсгүй муу алжаас үйлэнд автсан.
	Доголхуг далдаас хардсан нэг буруу.
Зүг зүгийн суурин улсын хотуудад мэдээлэгч, захирагч нарыг тавьж, улс иргэнийг хөл хөсөр, гар газар тавиулж амар төвшин болгов.	

Анд бололцох ёс

Алхам 1. Монголчуудын анд бололцох ёсны тухай уншаад, Тэмүжин Жамуха хоёр анд болохдоо солилцсон зүйлсийг нөхөөрэй.

	Эхний удаа анд болоход	Хоёр дахь удаа анд болоход	Гурав дахь удаа анд болоход
Жамуха Тэмүжинд өгсөн			
Тэмүжин Жамухад өгсөн			
Хаана анд бололцсон		- - -	

Алхам 2. Тэмүжин Боорчи хоёр хэрхэн нөхөрлөсөн бэ?

.....

.....

.....

.....

.....

Алхам 3. Тэмүжин Жамуха хоёрын эвдрэлцсэний шалтгаан юу байсан бэ?

Жамуха:

"Тэмүжин анд аа!

Ууланд шахан бууя.

Адуучинд гэр болтугай!

[Ай зөв үү? А.то.]

Голд шахан бууя

Хоньчин хургачин нарт

Хоол болтугай!

[Хориггүй биш үү? А.то.]” гэж хэлсний утгыг тайлаарай. Бөртэ үжин хэрхэн тайлсныг эргэцүүлээрэй.

.....

.....

.....


.....

.....



Монголын нууц товчооны дотор 1430 орчим мөр шүлэг байна. Үүний 900 орчим мөр нь хос мөрт шүлэг. Гурван мөрт шүлэг 50 удаа, дөрвөн мөрт шүлэг 30 удаа орсон байна. Нууц товчоонд аман, бичгийн яруу найргийн олон төрөл зүйлийн шүлэг орсончлон, хэмжээ холбоцын хувьд ч мөн харилцан адилгүй өвөрмөц хэлбэр маягтай шүлэг олон байгаагийн гэрч юм. Нэгэнт олон төрөл зүйлийг хамарсан элдэв шүлэг байгаа болохоор холбоцын хувьд хоёр мөртөөс гадна 3, 4, 7, 8, 10 гэх мэт янз бүрээр холбосон шүлэг олон.

Шүлэг судлал:



Бадаг: Аялга ба холбоцын нэгэн хэм зохицолд захирагдаж, тодорхой утга төгссөн хоёр буюу хэд хэдэн шадаас бүрдсэн айзам-өгүүлбэр зүйн нэгжийг шүлэг судлалд бадаг гэнэ.

Шүлэг судлалд бадгийг шадын тоогоор хоёрт, гуравт, дөрөвт... наймт, арван дөрөвт зэргээр, эсвэл толгой, сүүл, дунд холбох холбоцын давтагдах шинжээр нь ялгах нь бий. Монгол шүлгийн хувьд хамгийн богино бадаг хоёр шадаас бүрдэх ба эн тэнцүүлсэн хоёр мөртийг “хос уянга” гэнэ.

Бадгийн ачаар шүлэг эмх цэгцтэй, хэмжээ, хэмнэл нийцэж, эхний бадгийн бүтэц байгууламж, түүний хэмжээ, хэмнэл дараах бадгуудад давтагдах байдлаар шүлэгт тэгш хэмийг үүсгэнэ.

Бадаглалзүй: Шүлгийн бадаг хэрхэн бүтсэн, ерөнхий хэлбэр байгуулалтын онцлог, үүрэг, ач холбогдлыг голлон судалдаг шүлэг судлалын салбар.

Шад: Шүлгийн бадгийг бүрдүүлэгч гол хүчин зүйл буюу бадгийн доторх нэг мөрийг хэлнэ. Монгол шүлэгт их төлөв 2,4,6,8 тэгш шад бүхий бадаглал зонхилж, үүнээс 2,4 шадаар бадаглах ёс илүү өргөн дэлгэрчээ.

Холбоц: Шүлгийн хэлийг яруу сонсголонтой болгох зорилгоор ижил буюу төстэй, эгшиг болон гийгүүлэгч авиагаар гол төлөв мөрийн толгой, сүүлийг эхлэх, төгсгөх зэргээр айзам хэмнэлийг бүтээдэг дүрслэлийн ур маягийг холбоц гэнэ. Бадгийн эхлэл, төгсгөл нь ижил авиагаар холбогдсон бол тэгш холбоц, бадгийн эхлэл төгсгөл нь ижил бус, ойролцоо төстэй авиагаар сөөлжилж холбогдсон бол тэгш бус холбоц гэнэ.

Сэдэв: Яруу найргийн бадаглалыг тайлбарлах.

ӨЭЛҮН ЭХИЙН МАГТААЛ

(75-р зүйл)

Оюунтай төрсөн Өэлүн эх
Оёдолт дээлийг огшуулан өмсөж
Оготор хормойг шуун бүсэлж
Онон мөрнийг өгсөж уруудаж
Олирс мойлыг түүж явж
Өчүүхэн хөвүүдээ хайрлан тэжээж
Өдөр шөнийг аргацаан өнгөрүүлэв.

Чадалтай төрсөн үжин эх
Царсан шорыг барин явж
Цавчим газрыг өгсөж уруудаж
Сөдөн гичгэний үндсийг малтаж
Шөнө өдрийг хатамжин өнгөрүүлж
Суут хөвүүдээ тэжээн өсгөв.

[Хатан төрсөн үжин эх
Хайлаасан шор барин явж
Халдун уулыг өгсөн уруудаж
Хавийн мангирыг малтан түүж
Хаад хөвүүдээ хайрлан тэжээж
Ханатал цадтал идүүлж өсгөв. А.то.]

Гоо төрсөн Өэлүн эх
Гох дэгээ барин явж
Гол завьг өгсөж уруудаж

Гогод мангирыг түүн явж
Хутагтан хөвүүдээ тэжээж өсгөв.

Зарчимтай төрсөн үжин эхийн
Затгас төмсөөр тэжээсэн хөвүүд
Засагтан сайд болж өсөв.

Гоо төрсөн үжин эхийн
Гогод мангираар тэжээсэн хөвүүд
Хутагтан сайд болж өсөв.


Эх үжиний тэжээсэн хөвүүд
Эрс сайд болон өсөж
Эрх омог төгөлдөр болж
Эх Ононы эрэгт сууж
Өлгүүр гох усанд хаяж
Эрэмдэг загасыг шүүн барьж
Эх үжинийг тэжээх болов.

Зарчимт үжиний тэжээсэн хөвүүд
Засагт эрс болон өсөж
Замагтай усыг шүүрдэн байж
Загас жараахайг гэхидөн барьж
Заяат эхээ тэжээх болов.

Алхам 1. Шүлэгт ямар холбоц голлосон байна вэ?

.....

Алхам 2. Шүлэгт Өэлүн эхийг хэрхэн дүрсэлсэнг нөхөж бичээрэй.



Алхам 3. Өэлүн эх үр хүүхдээ хэрхэн өсгөсөн хэсгийг ахин уншаад дараах хүснэгтийг нөхөөрэй.

№	Ургамал	Хаана ургадаг гэж дүрсэлсэн	Толь бичгийн тайлбар
1	Олирс		
2	Мойл		
3	Сөд		
4	Гичгэнэ		
5		Халдун уулыг өгсөн уруудаж Гол завыг өгсөж уруудаж	
6			

Алхам 4. Дээрх дүрслэл шүлгийн утга санааг тодруулахад хэрхэн нөлөөлж байна вэ?

.....

.....

Алхам 5. Өэлүн эхийн зорилго биеллээ олсонг шүлэгт хэрхэн дүрсэлсэн бэ?

.....

.....

Бүтэц

Алхам 1. Дараах хүснэгтийг нөхөж бичээрэй.

№	Эшлэл	Шүлгийн мөр (Хос мөрт шүлэг, гурван мөрт шүлэг гэх мэт)	Шүлгийн холбоц
1	Урьж чамд өгөх ёсгүй Учирвал чи идэх ёстой Хүргэж чамд өгөх ёсгүй Хүртвэл чи идэх ёстой (71-р зүйл)		
2	Үхэж хэвтэх яс минь Үржилт эх дэлхийд Үүрд оршиж байгаад Итгэлт андын ургийг Ивээж тэтгэх болтугай гэж Ийм ерөөлийг тавья (201-р зүйл)	Гурван мөрт	
3	Адил зэргийн дайсанд Араа үзүүлж яваагүй Алалдах тулалдах өдөрт Агтаа ухруулж үзээгүй билээ (194-р зүйл)		
4	Хүзүүнд минь угаасан Хүнд модыг Хөсөр хаясан (146-р зүйл)		

Алхам 2. Өэлүн эх Тэмүжин, Хасар хоёрыг зэмлэн хэлсэн үгэнд:

Хавиргаа хазах хар нохой мэт
Хаданд довтлох харцага шонхор мэт
Уураа даран ядах омогт арслан мэт
Амьдыг залгих аюулт мангас мэт
Сүүдрээ довтлох сүрхий араатан мэт
Цугийг залгих цурхай загас мэт
Ботго тормын борвийг хазах өл буур мэт
Бороот өдөр довтлон халдах өлөн чоно мэт
Нялх үрээ гилэн ядаж, нядлан идэх нүгэлт ангир мэт
Хэвтшийг хөдөлгөвөл гэдрэг довтлох хэрцгий цөөвөр мэт
Барьж идэх барс араатан мэт
Балмад амьтад буюу

(78-р зүйл)

Дээрх хэсэгт уран дүрслэлийн ямар аргыг хэрэглэсэн бэ?

Шүлгийн утга, онцлогийг тодорхойлж бичнэ үү:.....

.....

Алхам 3.

Одтой тэнгэр орчиж
Олон улс байлдаж
Орондоо унтах завгүй
Олзлон булаалдаж байв.
Хөрст дэлхий хөрвөж
Хөвчин улс хямралдаж
Хөнжилдөө унтах завгүй
Хөнөөлдөн тэмцэж байв.
Эргэлзэн бодох чөлөөгүй
Элбэлдэн зүтгэж явав
Ухран дутаах газаргүй
Урагшлан байлдаж явав.
Амар жаргах аргагүй
Алалдан тэмцэж явав

(254-р зүйл)

Дээрх шүлгийн хэсгийг уншаад, тухайн үеийн нийгмийн байдлыг тодорхойлон бичээрэй

Алхам 4. Жамуха, нөхдөдөө баригдаж ирээд Чингис хаанд хэлүүлсэн нь:

"Хар хэрээ
Халтар нугасыг
Барих болов
Харц боол
Хан эзэндээ
Халдах болов.
Хаан анд минь
Хайрлаж өршөө
Бор элээ
Борлог нугасыг
Барих болов
Боол зарц
Бодот эзэндээ
Босож халдав.

Богд анд минь
Бодож үз”

Ийн хэлүүлэхэд Чингис хаан ямар арга хэмжээ авдаг вэ?

.....

Шүлгийн утга нь:

.....

Алхам 5. Найманы Таян хан:

Хар муусайн монголтой
Хатгалдаж нэгэнт эхэлбэл
Хагацахад бэрх болно.
Хацрыг жадалж байвч
Харсан нүдээ цавчдаггүй
Хар цусаа урсаж байвч
Харьж огт буцдаггүй
Хатуужил ихт монголтой
Хамаагүй байлдаж болохгүй.

(194-р зүйл)

Шүлэглэсэн хэсэгт монголчуудыг хэрхэн тодорхойлсныг үзээд, тухайн цагийн Монголчуудын зан чанарыг дүгнэж бичээрэй.

.....

.....

.....

Алхам 6.

Жамуха, Таян ханд Хасарын хүчийг өгүүлсэн хэсэгт

"Хүндэт Өэлүн хатны
Хүний махаар тэжээсэн
Хүчит Хасар гэдэг
Хүү нь тэр мөн
Гурван бухаар зүтгүүлэвч
Гулзайхгүй хүчтэй
Гунжин үхрийг идэвч
Цадахгүй ходоодтой
Хэдэн алд биедээ
Хэлхээ хуяг өмссөн
Хэрцгий догшин Хасар
Хэн бүхнийг идэхээр айсуй!
Хоромсого саадагтай хүнийг
Ховх татаад залгихад
Хомхой тэр Хасарын
Хоолойд тордоггүй гэнэ.
Амьд хүнийг бүхлээр
Авч шүүрээд залгихад
Аюулт тэр гайхлын
Аманд тээглэхгүй гэнэ.

Уур нь их хүрч
Урдах сумаа шүүрч
Ухасхийн харвахад
Уулын цаадах хүмүс ч
Уул суманд оногдож
Ундуй сундуй үхэлгээнэ.
Хилэн нь их хүрч
Хийсвэр сумаа шүүрч
Хийн зүг харвахад
Хярын цаадах хүмүүс ч
Хяргах тэр суманд
Хядагдаж олноор үхэцгээнэ.
Их дэлж харвавал
Есөн зуун алд газар харвадаг
Татуу дэлж харвавал
Таван зуун алд газар харвадаг
Хүнтэй адил хүн биш
Хүнийг идэх мангас
Хүчит Хасар тэр
Хүрч ирж явна

- Дээрх хэсэгт Хасарыг дүрслэхдээ уран дүрслэлийн ямар аргыг ашигласан бэ?

- Шүлгийн хэсгээс Хасарын гадаад шинж болоод зан чанарыг тодорхойлоорой.

Зан чанар:

Гадаад шинж:

- Хасарын хүү Есүнхэ мэргэний харвасан сум хэр хол туссанг Эдүгээгийн сур харваачдын тэмдэглэсэн хэмжээтэй харьцуулан үзэж, сур харвааны уламжлал, соёлын талаар баримт цуглуулан тэмдэглээрэй.

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Алхам 7. Тэмүжин Бурхан халдун дээр бууж, өвчүүгээ дэлдэж (цохиж) залбиран өгүүлрүүн:

"Солонго мэт сонсох
 Соргог Хуагчины
 Сонорын хүчээр
 Үен мэт үзэх
 Үнэнч Хуагчины
 Үзсэний ачаар
 [Аюулт дайснаас
 Амжин дутааж]
 Бүтэн биеэ
 Бүгэн нуугдаж...
 Бурхан халдунд
 Амь хоргодов.
 Харийн дайсан
 Халдан довтлоход
 Харцагаас дутаасан
 Болжмор мэт
 Хандгай бугын
 Мөрийг дагаж
 Хад хавчлын
 Сүвийг эрж
 Хулдун ууланд
 Дутааж ирээд
 Хальс холтсоор гэр барьж
 Халуун амиа
 Хамгаалав, би.

Бөглүү ойт
 Бурхан уул
 Бөөсөн чинээ амий минь
 Бөөцийлөн аварч
 Бөөрийн чинээ биеий минь
 Бүтэн мэнд үлдээв.
 Өшөөт дайснаас
 Өршөөн аварч
 Өнчин бидний
 Өмөг болсон
 Өндөр дээд
 Бурхан халдун чамайг
 Өглөө бүр мялааж байя!
 Өдөр бүр тахиж байя!
 Үрийн үрд
 Үүрд тахим
 Үе тутам
 Үргэлж шүтэе!"
 гэж бүсээ хүзүүнд эрих мэт өлгөж,
 малгайгаа гарт сэгэлдэрч, гараар
 өвчүүгээ дарж, наран өөд хандаж,
 Бурхан халдунд есөнтээ сөгдөж өчил
 өчин, сацал сацав.

(103-р зүйл)

Шүлгийн тодруулсан хэсгийн бадгийн бүтцийг тодорхойлоорой.

Мөр:

Холбоц:

Монголчуудын уул ус, газар шороогоо шүтэх ёсыг Бурхан Халдун уулын жишээн дээр суурилан тайлбарлаарай:

.....

.....

.....

.....

.....

Бүлэг сэдэв: МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНООС СЭДЭВЛЭСЭН ӨГҮҮЛЛЭГҮҮД

Түүхэн уран зохиол: Аливаа улс үндэстний оршин тогтнож ирсэн түүхийн баримтад тулгуурлан уран сэтгэмж, уран дүр, дүрслэлээр баяжуулж бичсэн зохиолыг хэлнэ. Түүхийг уран сайхны аргаар баяжуулах нь түүхэн уран зохиолын гол онцлог мөн.

Хүүрнэл. Зохиолч ба өгүүлэгчийн хэл яриагаар зохиолын үйл явдлыг өгүүлэх, үйл хөдөлгөөний дэс дарааллыг тогтоон дүрслэх аргыг хүүрнэл гэнэ. Хүүрнэл нь I, III биеийн хүүрнэл гэж үндсэн хоёр хэлбэртэй. Зохиолын аль ч хэсэгт хэчнээн ч удаа дүрслэлийн аргын үүргээр ордог.

Өгүүлэгдэхүүн: Зохиолын үйл явдлын бүтэц дарааллыг өгүүлэгдэхүүн гэнэ. Өгүүлэгдэхүүн нь дүр, юмс үзэгдлийн эмх замбараагүй хөдөлгөөн бус сайтар бодож боловсруулсан уран сайхны зорилго бүхий учир зүйн нарийн холбоо, зохион байгуулалт, дараалал бүхий үйл явцыг илтгэсэн ойлголт.



Эхлэл: Зохиолын үндсэн зөрчил үүсэх учир шалтгаан, баатруудын хооронд үүсэх харилцаа, түүний шинж, хэв маяг, нийгмийн нөхцөл байдал, зохиолын ерөнхий үзэл санаа, зохиолдоо дэвшүүлсэн асуудал, дүр, зорилго сэлтийн талаар дэлгэрэнгүй биш боловч урьдчилан ямар нэг төсөө таамаг төрүүлэхүйц дүрслэлээр урьдчилан танилцуулах зорилготой хэсгийг эхлэл гэнэ.

Зангилаа: Зохиолын эхлэл хэсгийг залган хөгжүүлж, цаашдын хэрэг явдлын үндсэн зөрчлийн эхлэлийг тавьж, үйл явдлын чөлөөт өрнөлийг хангаж өгдөг зохиолын хэсэг. Зохиолын өрнөлийн үндэс нь зөрчил бөгөөд тэр нь зангилааг үүсгэж, сонирхолтой, нууцлаг, тайлал шаардах нь зохиолын ерөнхий өрнөлийг хангаж, уншигчийг татах уран сайхны хүч чадалтай болгодог.

Өрнөл: Зохиолын зангилааны учир зүйг олоход чиглэсэн, чөлөөтэй хөгжиж байгаа үйл явдлын үндсэн хэсгийг өрнөл гэнэ. Өрнөл зохиолын үйл явдлын үндсэн гол хэсэг бөгөөд зөрчил тэмцэл чөлөөтэй өрнөн хөгжих талбар юм.

Туйл: Зохиолын өрнөлөөр зөрчил тэмцэл алгуур жам ёсоороо хөгжсөөр цааш үргэлжлэх аргагүй болтлоо хурцдаж, дээд цэгтээ хүрэхийг өгүүлэгдэхүүний туйл гэнэ. Туйл өгүүлэгдэхүүний гол зүйлсээс хамгийн хурц, сэтгэл хөдөлгөм, анхаарал төвлөрүүлсэн хэсэг юм.

Тайлал: Зохиолын зөрчил тэмцэл өрнөсөөр туйлдаа хүрч, улмаар шийдэгдэж буй хэсэг. Тайлал зохиолын зангилаанаас шууд хамааралтай бөгөөд зохиолын утга санааг төгс болгож төгсгөдөг.

Төгсгөл: Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлсэн хэсэг.



Сурагчийн овог нэр:
.....

Эхэлсэн....онсар.....өдөр.....цаг
Дууссан....онсар.....өдөр.....цаг

Хичээлийн сэдэв: Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлах

Хүүрнэн өгүүлэгчийн мэдээлсэн орон, цаг, дуу хоолойг тодорхойлъё.

Алхам 1. Зохиол эхлэл, гол, төгсгөл хэсгийн өгүүлэгч болон гурван цагийн дүрслэлийг тодорхойлоорой.

	Эхлэл	Гол	Төгсгөл
Эшлэл	...Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр өнөөдөр талын болжмор жиргэж эх нутгийн ноён салхинаа гудайсан хялганын толгой гашуудалтайяа бөхөлзөнө.	...Монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ. Олон аймгийн цуст тэмцэл талын язгууртнуудын өрсөлдөөн Тэмүүжингийн ялалтаар төгсөж байсан тэр жил...	...Найман зууны тэртээх Жамухын шарил дээгүүр эх нутгийн ноён салхи гунигтайхан хэсүүлчилж нөхрийн тухай үгсийг хялганын бутанд шивнэн эрин зуунд илгээнэ.
Хэддүгээр биеэс хүүрнэн өгүүлж байна вэ?			
Ямар цагийн утгыг зааж байна вэ?			

Алхам 2. Хүүрнэн өгүүлэгчийн мэдээлсэн эхлэл болон төгсгөл хэсэг зохиолд ямар үүрэгтэй орсон гэж бодож байна вэ?

.....
.....

Алхам 3. Дараах хэсэгт өгүүлэгчийн дуун хоолойн өнгийг тодорхойлж бичээрэй.

..хялганын толгой гашуудалтайяа бөхөлзөнө:

..Монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын түүхийг өгүүлнэ:

...Дорно зүгт нар хаана манддагийг очиж үзэгтүн! :

..Баатар Жамухын сүүлчийн өчил гэрээсийг биелүүлж цус гаргалгүй үхүүлэгтүн! :

.....

...хаадын зарлиг ёсоор болж, мөнх тэнгэрийн таашаалд нийцэв.:

Өгүүлэгдэхүүний бүтэц холбоо хамаарлыг тодорхойлъё.

Алхам 1. Зохиолын үйл явдал хэрхэн эхэлсэн бэ?

.....

Алхам 2. Зохиолын үйл явдлын гол зөрчил яаж илэрсэн бэ?

.....

Алхам 3. Зохиолч хэрэг явдлыг хэрхэн дараалж, өгүүлэгдэхүүнээ яаж зохион байгуулсныг зураглан харуулаарай.

Алхам 4. Жамухын өчил өгүүллэгийн Өгүүлэгдэхүүний үйл явдлын бүтцийн дарааллыг гүйцээн бичээрэй.

№	Өгүүлэгдэхүүний бүтэц	Үйл явдал
1	Эхлэл	Олон аймгийн цуст тэмцэл Тэмүүжингийн ялалтаар төгсөж байв.
2	Зангилаа	
3	Өрнөл	
4	Туйл	
5	Тайлал	
6	Төгсгөл	Хаадын зарлиг ёсоор болж, мөнх тэнгэрийн таашаалд нийцэв.

Алхам 5. Эхлэл болон төгсгөл хэсгийн хүүрнэл, зохиолын өгүүлэгдэхүүн бүтэцтэй хэрхэн холбогдож буйг тайлбарлан бичээрэй. Ингэхдээ эхлэл болон төгсгөл хэсэг өгүүлэгдэхүүний бүтцэд ороогүйг анхаараарай.

.....

.....

.....

Алхам 6. Монголын нууц товчоо болон Жамухын өчил зохиолд Чингис хааны дүрийг хэрхэн дүрсэлсэнг харьцуулан үзээрэй. (200, 201-р зүйлийг дахин уншаарай)

Чингис хаан:

Зохиол	Жамухыг барьж ирсэн нөхдөд авсан арга хэмжээ	Жамухад тавьсан санал	Гаргасан шийдвэр	Хариу үзүүлж буй сэтгэлийн өнгө аяс
Монголын нууц товчоо				-х-

Жамухын өчил				
--------------	--	--	--	--

Бүлэг сэдэв: ӨГҮҮЛЛЭГ

Д.Нацагдорж “Ламбугайн нулимс”

Дүр: Уран зохиолд амьдралыг тусган гаргах аргыг дүр гэнэ. Дүр нь зохиолын үйл явдлын өрнөлийн бүхий л явцыг өөртөө тээн хадгалагч, хөтлөгч хэрэгсэл.

Уран сайхны дүр нь бодит ба хийсвэр шинжтэй байдаг.

Бодит шинж: Дүрийн дүрслэгдэж байгаа орчин, түүх, цаг хугацаа болох цаад дэвсгэр тал буюу амьдрал болно.


Хийсвэр шинж: Зохиолчийн ургуулан бодох бодлын үр дүн, дүр бүтээх арга маяг буюу туурвилзүйн тал юм.



Сурагчийн овог нэр:
.....

Эхэлсэн.....онсар.....өдөр.....цаг
Дууссан.....онсар.....өдөр.....цаг

Хичээлийн сэдэв: Зохиолын бодит ба хийсвэр дүр нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах.



Алхам 1. Зохиолд Гэвш Лодонг тодорхойлсон үгсийн утгыг тайлбарлаарай.

Винайн ёс:

.....

Гэвш:

Улаан шар өнгөний бэлгэдэл:

.....

Дээрх дүрслэлүүдээс Гэвш Лодонг зан чанарыг тодорхойлоорой:

.....

Алхам 2. Гэвш Лодон Цэрэнлхам хүүхэнд “Зүүн хүрээнд хуралд очиж явнам. Энэ удаа амжихгүй. Өөр нэг ламыг залсугай” гэж хэлдэг. Гэвч бодлоо өөрчилсөн шалтгаан юу байв?

.....

.....

Алхам 3. Цэрэнлхам хүүхнийг дагаж явснаар зохиол өрнөх гол зангилаа болдог билээ. Тэгвэл дагаж явсан нь Гэвш Лодонгийн буруу юу эсвэл өөр хүчин зүйлс /Цэрэнлхам хүүхэн, тухайн үеийн нийгэм гэх мэт/-ийн буруу юу гэдгийг баримт гарган тайлбарлаарай.

.....

.....

.....

.....

Алхам 4. 1910-аад оны үед Монгол улсын хүн ам таван зуун мянга гаруй байжээ. Тэр үед Монголд 755 буддын сүм болон 12 мянга гаруй лам байсан гэж үздэг. Үүнд үндэслэн “Гэвш Лодон” дүрийн бодит шинжийг тодруулаарай.

Бодит шинж

Алхам 5. Цэрэнлхамын гадаад шинж болон зан чанарыг зохиолд хэрхэн дүрсэлсэнг түүж бичээрэй.

.....

.....

.....

.....

Алхам 6. Зохиолын эхлэл хэсэгт Лодон лам болон Цэрэнлхам хүүхний уулзах үеийг хэрхэн дүрсэлсэнг ажиглацгаая.

Дүр	Гэвш Лодон	Иүй Бай-хуа буюу Цэрэнлхам
Тодотгол	Орчлонт ертөнцийг хоосон хэмээх хүрдийг бясалгаж, винайн ёсыг сахисан	Урин тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан хүүхэн
Хэрхэн гарч ирсэн	Улаан шарыг тунуулсаар	Хар цагааныг гялбалзуулсаар
Хаанаас гарч ирсэн	Гандангийн наад хүр рүү	Баруун дамнуурчны шавартай гудамжнаас

Дүрслэлийн онцлогийг тайлбарлан бичээрэй:

.....

.....

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Соёлын хам сэдэв: Соёлыг бүрдүүлэгч элементийн нэг нь мэдлэг. Шашин, шинжлэх ухаан, урлаг зэргийг мэдлэгийн төрөл гэж нэрлэдэг. Иймээс шашин нь соёлын хам сэдвийг тодорхойлно. *“Ертөнцөд таван хүсэл бий. Тэдгээр нь хүний нүд аятайхан хэлбэр галбирыг олж харах, чих аятайхан ая дууг сонсох, хамар аятайхан анхилууныг үнэрлэх, аятайхан амтнаас арааны шүлс асгарах, гар аятайхан юмыг мэдрэхэд буй болно.”* гэж “Бодь мөрийн зэрэг”-т өгүүлжээ. Үүнийг хүслийн таван эрдэм гэдэг байна. Хүслийн таван эрдэм бол бэлгэдэл. Бурхан шүтээнд хэрэглэдэг дүрс, дуу, үнэр, амт, хүртэхүйн бэлгэдлийн хүслийн таван эрдмийг бурхны мэлмий, чих, хамар, хэл, лагшинд зориулан өргөж байгаа нь тэр ажээ. Бурхдын чуулганд тахил болгон бүтээсэн “Таван тахилын эгшиг” дуун өргөл нь “Үлэмжийн чанар” дуу юм.

1

Дасгал 1. Шүлгийг соёлын хам сэдвийн үүднээс тусган эргэцүүлэх**Алхам 1.** Шүлэгт юуны тухай өгүүлснийг баримтаар нотолж тайлбарлаарай.

.....

.....

.....

Алхам 2. Шүлгийн агуулгаас сайхан эмэгтэйн тухай ямар ойлголттой болсон бэ?

.....

.....

.....

Алхам 3. Дараах үгийн утгын тайлбарт шашны агуулга бүхий утга байна гэж үзвэл аль нь вэ?

Л а г ш и н	Ихэс дээдсийн биеийн хүндэтгэлийн үг
	Бурхны биед байх сайн бэлгэс / гурван лагшин (номын лагшин, төгс лагшин, хувилгаан лагшин);
	Биеийн байдал

З а н д а н	Халуун оронд ургадаг,
	зууван навчтай,
	анхилам үнэрт, хатуу
	чанарын мод

Б а д а м	Бурхны суурины эргэн тойрон товойлгон хийсэн бадам цэцгийн дүрстэй нэгэн зүйлийн хээ
	Дэн, зулын голд багсайн суусан багшмал хөө
	Найман тахилын дөрөвдүгээрх нь

.....

.....

.....

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Үндэсний ижилсэл: Үүнийг үндэстэн гэдэг ойлголттой холбож үзэх нь зөв юм. Үндэстэн гэдгийг хэл, газар нутаг, эдийн засаг, соёлын нийтлэг байдалтай ард түмэн гэж тодорхойлдог. Үндэсний ижилсэл гэдгийг хялбар тодорхойлбол хүн өөрийгөө аль нэг улс, үндэстэнд хамааруулан ойлгох тэр мэдрэмж, шинж тэмдгийг хэлдэг ажээ.

Энэ нь тухайн ард түмний бусад улс үндэстнээс ялгарах ялгарал нь болдог.

Үнэ цэнт зүйл: Эрхэмлэн дээдлэх зүйл.

1

Дасгал 1 . Соёлын хам сэдвээс үндэсний ижилсэл үнэ цэнт зүйлсийг ойлгох

Алхам 1. Шүлгийн ил ба далд утгыг илрүүлж болох үгсийг харгалзуулна уу.

А	Харгалзаа	В
1. Харах мэдрэхүйд өртөх гоо сайхан		А. Үнэртэн хүжис
2. Сонсох мэдрэхүйд өртөх дуу хоолой		В. Үнэт чухал сургаал
3. Үнэрлэх мэдрэхүйд өртөх сайхан үнэр		С. Ном судар
4. Амтлах мэдрэхүйд өртөх сайхан амт		Д. Хир буртаггүй, сэв тотгоргүй жаргахын ерөөл
5. Хүрэлцэх мэдрэхүйд өртөх сайхан таатай зүйл		Е. Номын уншлага

Алхам 2. Дээрх даалгаврын А ба В эгнээнд байгаа зүйлийг хэрхэн тодорхойлж болох вэ?

- А:
- В:

Алхам 3. Д.Равжаа энэ шүлгээ зохиосны дараа “Нэг удаа чин сэтгэлээсээ дуулахад 1000 удаа дарь эхийн тарни уншсантай адил буян хураана.” гэж хэлсэн гэдэг. Үүнийг юу гэж тайлбарлаж болох вэ?

.....

Алхам 4. Эндээс монголчуудын хувьд үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлс нь юу байж болохыг тодорхойлоорой.

.....

Дууссан:онсарөдөр

Б.Явуухулан “Хар-Ус нуурын шагшуурга”шүлгийн айзам,
эгшиглэл, бадаглалыг тайлбарлах

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Айзам: Хүн төрөлхтөн байгаль, нийгэм, хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад таньж мэдсэн хөдөлгөөн, ая хөгийн зохилдсон давтамжит үзэгдэл/модны найгаан, усны хоржигноон, дуу чимээ, хөдөлгөөний давтамж/-ийг үгийн урлагт ашиглахдаа айзам гэж нэрлэжээ. Хэлний буюу авианы айзам нь шүлгийн хэлбэрийг бүтээх үүрэгтэй.

Эгшиглэл: Шүлгийн яруу сонголт чанар, уран хөг аялгууг бүрдүүлэн амилуулах зүйл нь авиа юм. Яруу найрагт хөгжимлөг, сонголт, хөг аялгууны сайхан зохирол бүрдүүлэхэд эгшиг болон бусад авианы сонголт, эгшиг зохицох ёс, дуудагдах байдал чухал үүрэгтэй.

Бадаглал: Аялга ба холбоцын нэгэн хэм зохицолд захирагдаж, тодорхой утга төгссөн хоёр буюу түүнээс дээш шадаас бүрдсэн нэгжийг бадаг гэнэ. Бадгийн ачаар шүлэг эмх цэгцтэй, хэмжээ хэмнэлтэй болдог.

1

Дасгал 1. Шүлгийн айзмыг тодорхойлоорой.

Алхам 1. Шүлгээс юуг мэдэрч байна вэ? Эшлэл авч тайлбарлана уу.

Харах мэдрэхүй:

Сонсох мэдрэхүй:

Алхам 2. Исгэрч байгааг ямар үг, авианаас сонсож байна вэ?

.....

2

Дасгал 2. Шүлгийн эгшиглэлийг тодорхойлоорой.

Алхам 1. Байгалийн ямар хөг аялгуу шүлгээс эгшиглэж байна вэ?

-
-
-

Алхам 2. Ямар улирлын өнгө аяс харагдаж байна вэ? Үүнийг юунаас мэдэрч болох вэ?

.....

Алхам 3. Хүний сэтгэлийн ямар өнгө аяс мэдрэгдэж байна вэ? Үүнийг шалтгаан үрийн холбоогоор тайлбарлана уу.

.....

3

Дасгал 3. Шүлгийн бадаглалын онцлогийг тодорхойлоорой.

Алхам 1. Шүлгийн бадгийн онцлогийг дараах загварын дагуу тодорхойлоорой.

Намрын сэрүү унахлаар

Нуурууд ийм байдаг юм уу?

Хотон шувуудаа явчихлаар

Хатан Хар-Ус уйдаа юу?

Шад/ мөр/ бүрийн үгийн тоо:

Толгой холболт:

Сүүл холбоц:

Алхам 2. Энэ бүхнээс үзэхэд шүлгийн онцлогийг

.....

.....

..... гэж тодорхойлж болох юм.

Дууссан:онсарөдөр

Д.Равжаагийн “Дөрвөн улирал” шүлгийг уншиж, сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах

Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр



Далд утга гэдэг нь хам сэдвээр дамжин илэрдэг санаагаа нуух үзэгдэл. Далд утга бүхий үг, уран дүрслэл буюу дүрслэх ур маяг, бэлгэдлээр илэрдэг.

1 Дасгал 1. Хүний амьдралын онцлогийг харуулсан эшлэлийг тайлбарлаарай.

Алхам 1. Шүлгийн хэсэг тус бүр дэх хүний насны онцлогийг харуулсан эшлэлийг ялгаж бичээрэй.

Өсөх цаг :

Идэр цаг:

Өтлөх цаг:

Өнгөрөх цаг:

2 Дасгал 1. Дараах тайлбарт тохирсон дүрслэлийг олж бичээрэй.

Алхам1. Хэсэг тус бүрийн гол санааг тайлбарлаарай.

• Өсөх цаг :

• Идэр цаг:

• Өтлөх цаг:

• Өнгөрөх цаг:

Алхам 2. Алхам 1 даалгавраас шүлгийн гол санааг тайлбарлаарай.

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....
.....

Дууссан:онсарөдөр

Д.Равжаа “Дөрвөн улирал”шүлгийн хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг задлан шинжлэх



Яруу хэрэглүүр: Өгүүлбэр зүйн ур маягуудыг үүнд хамааруулж ойлгож болно. Үг хэлний дүрслэх дүрслэх бололцоо хязгааргүй байдаг. Өгүүлбэр зүйн ур маяг гэдэгт төрөл бүрийн давталт, ахиулал, зэрэгцүүлэл, харшуулал зэргийг багтаадаг.

Харшуулал: Эсрэг тэсрэг ухагдахуун, санаа, шинж төрхийг илэрхийлэх зорилгоор үг хэллэг, дүрслэлийг зэрэгцүүлэн тавьж үл зохилдохыг илэрхийлдэг.

Ахиулал: Үг хэлээр, хүний сэтгэлийн хөдөлгөөн, үйлийн явц, өрнөлийг багаас их рүү, энгийнээс нарийн руу, эрчимжүүлж, ахиулж, илэрхийлэх давталт юм.

1 Дасгал 1. Яруу хэрэглүүрээр баялаг шүлэг болохыг батлаарай.

Алхам 1. Шүлгээс харшуулал бүхий жишээ олж бичээрэй.

- Зун:
- Өвөл:

Алхам 2. Шүлгийн дараах эшлэлд ямар утга агуулагдаж байна гэж үзэж байна вэ?

Эгүүрд байгаа хэлбэртэй байдаг л
Жавартай өвлийн хүйтнийг мартана л
Нарны дулаан элч буурна л
Насны идрийн цогоор нөгцөөв л

Алхам 3. Шүлгийн дээрх эшлэлд давтагдаж байгаа ямар баймж бүтээвэр байна вэ?

-

Алхам 4. Давтагдаж байгаа баймж бүтээврийг “ч” –ээр соливол ямар утга илрэх бол...

Алхам 5. Шүлгийн утгыг хэрхэн ахиулсныг нөхөж бичээрэй.

.....

.....

.....

Элдэв наадам тохууныг даган явсаар

Алхам 6. Ажилласан даалгавартаа тулгуурлаад шүлгийн хэл найруулгын онцлогийг дүгнэж бичээрэй.

Энэ бүхнээс үзэхэд “Дөрвөн улирал” шүлэг

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



1

Дасгал 1. Хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх

Алхам 1. Шүлгийн хэсэг тус бүрээс юуг мэдэрснээ хүснэгтэд нөхөж бичээрэй.

	Хавар	Зун	Намар	Өвөл
Харах
Сонсох		
Үнэрлэх
Амтлах			
Хүрэлцэх		

Алхам 2. Дээрх мэдэрсэн зүйл дээрээ тулгуурлаад дараах хам сэдвийг тодорхойлно уу.

- Нийгмийн хам сэдэв:
.....
.....
- Соёлын хам сэдэв:
.....

Дууссан:онсарөдөр

Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлгийг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгох

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



Үндэсний ижилсэл: Үүнийг үндэстэн гэдэг ойлголттой холбож үзэх нь зөв юм. Үндэстэн гэдгийг хэл, газар нутаг, эдийн засаг, соёлын нийтлэг байдалтай ард түмэн гэж тодорхойлдог. Үндэсний ижилсэл гэдгийг хялбар тодорхойлбол хүн өөрийгөө аль нэг улс, үндэстэнд хамааруулан ойлгох тэр мэдрэмж, шинж тэмдгийг хэлдэг ажээ.

Энэ нь тухайн ард түмний бусад улс үндэстнээс ялгарах ялгарал нь болдог.

Үнэ цэнт зүйл: Үнэ цэнт зүйлсийг амьдралыг үзэх үзэл гэж ойлгож болно. Хувь хүний үнэт зүйл нь удаан хугацааны туршид тогтвортой оршин байдаг итгэл үнэмшил бөгөөд улс үндэстний үнэт зүйлд хандах хандлагад ч илэрч байдаг.

2

Дасгал 2. Үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсийг тодорхойлох

Алхам 1. Амьдралын чанарын үзүүлэлтийг дараах зүйлээр тодорхойлдог гэж үзвэл түүнд хамаарч болох дүрслэлийг шүлгээс ялган бичээрэй.

Амьдралын чанарын үзүүлэлтүүд	Баримт эшлэл
Хүний дундаж наслалт
Боловсрол
Эрүүл мэнд
Соёл
Амралт
Хоол хүнсний зардал

Дууссан: он сар өдөр

Д.Нацагдорж “Дөрвөн цаг” шүлгийг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгох

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Алхам 2. Амьдралын чанарын үзүүлэлтийн дагуу ялгаж бичсэн баримт эшлэлээ тайлбарлана уу. Монгол хүний хувьд гэх маягаар

- Хүний дундаж наслалт:
- Боловсрол:
- Эрүүл мэнд:
- Соёл:
- Амралт:
- Хоол хүнсний зардал:

Алхам 3: Амьдралын чанарын үзүүлэлт дээрээ тулгуурлаад монголчуудын үндэсний ижилсэл, үнэт зүйлсийг тодорхойлно уу.

.....
.....
.....
.....

Зохиолын бодит ба хийсвэр дүр утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



“Зохиолын үйл явдлыг гүнзгийрүүлэх, дүрээ тодотгох гэж хийсвэр дүрийг бүтээдэг... Хийсвэрлэл бол хэзээд байсан. Элэнц хуланц, хэдэн мянган жилийн өмнө ч хангарьд, луу гэх зэрэг хийсвэр дүрүүдийг сэтгээд бий болгочихсон байна. Энэ чинь асар их хөгжил...” МУ-ын Төрийн шагналт зохиолч Д.Норов

Дасгал 1

Алхам 1.

Машука хаан: “...Аяа, охин чи маш тэнэг ажгуу...Варнасийн өчүүхэн хаан эд таваараар ядмаг цагаан дээлт түүнд юу санаж, цэцгийн эрихсийг цацав, чи” гэхэд охин Мадимаханийн хэлсэн үгийг зөв тохируулж бүтээгээрэй.

1.Эрхэм баян номоор баялаг нь	а. дундаж	4. Оюун эд лүгээ төгс нь
2.Идэр цогоор баялаг нь	б.доод	5. Охь сүжгийн эдтэн нь
3.Эгэл эдээр баян нь	с. дээд	6. Олз өлгийн эдтэн нь

1,4... 2,5..., 3,6...

Алхам 2. Машука хаан охиныхоо үгийн хариуд “... тийм муу цаг болсон тул ... туршиж асуусан бүлгээ. Алаг үгүй шударга явдал шүтэж чадахыг мэдэж,.. сэтгэл минь үнэхээр баясаж байна” гэж хэлдэг. Тийм муу цаг гэсний өмнө хэлсэн үгийг зөв тохируулж бүтээгээрэй.

1.Чанарын сайныг хэрэглэхгүй	а. Царайны сайныг хэрэглэх
2.Сэтгэлийн сайныг хэрэглэхгүй	б.Олзны сайныг хэрэглэх
3.Явдлын сайныг хэрэглэхгүй	с. Башир үгтэнг хэрэглэх
4.Буянт сэтгэл ихтэйг хэрэглэхгүй	д.Алдар ихтэйг хэрэглэх
5.Бат зантанг хэрэглэхгүй	е. Өнгөний сайныг хэрэглэх

Алхам 3. Машука хааны охиноо үдэж явуулахдаа хэлсэн үгийг зөв тохируулж бүтээгээрэй.

1.Нөхөр хаандаа	а. Эх мэт энэрч зохио
2.Зэргийн олон хатадтай	б. могой үзсэн мэт зайлж зохио
3.Номт түшмэдтэйгээ	с. боол эм мэт биширч зохио
4.Доод албатууддаа	д. шувууны далавч мэт атаа үгүй зохио
5. Чивэлт шуламсын нөхрөөс	е. оройн гавал мэт хүндэлж зохио
6.Ариун дээд номын нөхрийг	ж. ах дүү мэт ханилж зохио

Дууссан:онсарөдөр

Зохиолын бодит ба хийсвэр дүр утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 2. Сорилыг ажиллаарай.

Алхам 1.

“Отгой нөхрийн аргаар хүүрт ороод

Осолдож ийм хөхөө биет болов, би” гэсэн нь ямар бодит дүрийн хийсвэр шинж болохыг сонгоорой.

А. Гулиранз В. Машука С. Номунбаясгалан D. Лагана

Алхам 2.

Дараах бодит ба хийсвэр дүрүүдийн дарааллыг ажиглаад зөвийг сонгоорой.

Саран хөхөө, Номунбаясгалан, Очирваань, Машука, Мадимахани, Гэтэлгэгч дар эх, Лагана,

А. Ямши В. Хуурамч хан хүү С. Сурасдини D. Сэрсэнма

Алхам 3.

Хан хүүг үгүй хийх санаа гаргасан хатны нэр хэн бэ?

А. Мадимахани В. Эйлэг С. Сурасдини D. Сэрсэнма

Алхам 4.

“Ихсийг зусардаж өмөгтэй болох хэрэгтэй

Улсыг хуурч олон албаттай болох хэрэгтэй

Номч хүнд сүжигтэй мэт загна

Ноён хүнд ухаантай мэт загна

Олон хүнд хүчтэй мэт загна

Хүнийг өөрийнх нь үгээр алахаас илүү мэс үгүй

Өөрийн биед эс мэдсэнээс илүү бамбай үгүй...” гэж хэлсэн хүний нэр хэн бэ?

А. Ямши В. Хуурамч хан хүү С. Гулиранз D. Машука

Алхам 5

“...Омог урин, харам атаа, самуун үгийг тэвчигтүн

Олон албат улсаа эх нь мэт энэрэгтүн

Гурван үүдний аливаа юмаа хан хөвгүүнд бүү нуу

Хутгагч шумна түшмэлийн хов үгийг бүү хэрэгс

Үеийн хатны муу үйлдсэнийг хүлц

Өс сэтгэл бүү хадгал

Хөл үгүй аглаг суугтун...” гэж хэн, хэнд, хэзээ захидаг вэ?

Хэн?

Хэнд?

Хэзээ?

Дууссан:онсарөдөр

**Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн
холбоо хамаарлаар далд утгыг тайлан
тайлбарлах**

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр



“Саран хөхөөний намтар” жүжиг нь олон сургаалын шүлгүүдтэй. Үүнд шашны гүн ухааны ойлголтуудыг тусган номлоно. Жүжиг нь амьдралын утга учрын тухай, ертөнцийн амьдрал мөнх бусын тухай гүн ухааны санааг илэрхийлдэг.

**Дасгал 3.
Алхам 1**

“Саран хөхөөний намтар” жүжгийн төрөл зүйлийн онцлогийг гүйцээн дүгнэж бичнэ үү.

Бурхан шашны гүн ухааны драм	Нийгмийн драм
Бодит хүмүүсийн дүрээс гадна бурхад, дүр олон гардаг. Жишээ нь: Машука хаан нь Очирваань бурхны хувилгаан, Мадимахани хатан Арьяадарь буюу гэх мэт.	Хаан эцгүүд охидоо сургаж байгаа сургаал нь хүний нийгэмд зөв байх ёс суртахууныг заан сургаж байна. Жишээ нь: “Зэргийн олон хатадтай шувууны далавч мэт атаагүй зохио” гэснээрээ гадна олон эхнэр авдаг ёс заншил байсныг давхар илэрхийлж байна.
Дүрүүдийн юу хийх яавал зөвийг дээд тэнгэрээс хэлж чиглүүлдэг. Жишээ нь: Номунбаясгаланг хөхөө болсноос хойш тусалж дэмжин зааж зөвлөдөг Хувилгаан хөхөө. 9-р бүлгийн эхэнд үхэх цаг нь болсныг хэлнэ гэх мэт.	Дэвшилтэт болон харгис хүчний тэмцлийг харуулсан. Жишээ нь: Машука, Гуларанз, Чагнаа зэрэг сайн хаад, Ямши, Лагана зэрэг муу түшмэл, хааны тухай гэх мэт.
Аливаа амьтны сүнс гэсэн бурхан шашны үзэл гарч байна. Жишээ нь: Номунбаясгалан хүн биеэ Лаганад булаалган хөхөө шувуу болсон. Лагана хан хүүгийн биед хувирсан гэх мэт.	Эрх мэдлийн төлөө улайрдаг нийгмийн шударга бусыг илчилсэн. Жишээ нь: Ямши, Лагана тэр битгий хэл аглаг ойн амьтдын дунд ч байгааг Хулд шувуугаар төлөөлүүлсэн гэх мэт.
Муу үйлийн үр зовлон, сайн үйлийн үр жаргал болохыг номлосон. Жишээ нь: Номунбаясгалан хөхөө болсон нь урьд насандaa умар зүгийн хааныг дайлаар моргсоноос болсон гэх мэт.	Гэмгүй хүмүүсийг хэлмэгдүүлдэг нийгмийн шударга бусыг илчилсэн. Жишээ нь: Эйлэг хатанг хаанд ховлоно. Эйлэг хатан “Би гэмгүй бөгөөс хатсан тутаргаас цэцэг ургах болтугай” гэнэ. Ямши 3 түшмэлийг гүтгэнэ.
Эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийн тухай олон удаа гарна. Жишээ нь: Номунбаясгалангийн өмнөх төрөл, төрөхөд нь өөр биед хувирах эш гэх мэт.	Нэгэндээ атаархан тэмцдэг нийгмийн шударга бусыг илчилсэн. Жишээ нь: Сурасдини хатан

Дууссан: он сар өдөр

Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Дасгал 4.

Алхам 1

Доктор Л.Хүрэлбаатарын дүгнэлтийг гүйцээн нөхөж, зохиолын утга санааны тухай ойлголтоо бататгаарай.

Ашиглах үгс: бүтээх хийхийн, алжаах умартахыг, атхаг, үргүй дэмий

“Аврал учрал, найман чөлөө бүрдсэн” гэх эрдэнэт хүний биеийг олсон боловч сэтгэл, агаа тэмцэл, хорголзох хомголзох муу сэтгэлээр нэгэн насыг барснаас адгуусан төрөлт болсон боловч мартан номлох бүтээхэд зорьсон өчүүхэн шувууны явдлыг үлгэрт авч хүн гэгч ямар их гайхамшгийн боломжийг авахын хувь төгссөн хэрнээ тэр боломжийг ямар их алдахын гэм “төгссөн”-ийг уран сайхан дүрийн хэлээр нээн гаргаж сурган номлосон юм.

Алхам 2

“Саран хөхөөний намтар” жүжгийг XIX зууны эхний хагаст зохиосон ч одоо цагт хэрэг болох ямар ямар санаа, сургамжийг олж авснаа бичнэ үү.

Өөрт ямар санаа, сургамжийг тусган авсан бэ?	Ямар дүрээс	Ямар үйл явдлаас
Өөрийн амьдарч байгаа цаг үе, нийгмийн хандлагад зөв үнэлгээ өгч авах гээхийн ухаанаар хандахыг ойлгосон гэх мэт.	Машука хаан	...тийм муу цаг гэж хэлээд дурдаж байгаа шинжүүд нь одоогийн нийгэмд ч байгааг ойлгосон.
.....
.....
.....
.....
Үр хүүхдээ буруу үйлд сургавал эцэст нь өрх гэрийн амьдрал төдийгүй улс оронд нь гай зовлон учруулдаг гэдгийг ухаарсан гэх мэт.	Гулиранз хааны их түшмэл Ямши	“Ихсийг зусардаж өмөгтэй болох хэрэгтэй Улсыг хуурч олон албаттай болох хэрэгтэй...” гэж буруу зүйлд зааж сургасан хүүгийнхээ алдаанаас болж гэр бүлээрээ сүйрсэн
.....
.....
.....
.....

Дууссан:онсарөдөр

Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц, орчин нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тайлбарлах

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Алхам 1.

“Саран хөхөөний намтар” жүжгийн өгүүлэгдэхүүний бүтцийг гол зөрчлөөр хуваан гүйцээн бичээрэй.

Өгүүлэгдэхүүний бүтэц	Жүжгийн үйл явдал
Эхлэл	1-р бүлэг, 2-р бүлгийн 1-6-р үзэгдэл
Зангилаа	Хааны их түшмэл Ямши нь хүү Лаганаг түшмэл болгох ов мэх зохиож буй хэсэг
Өрнөл
Туйл	Номунбаясгалан хан хүү хөхөө шувууны биед хувирна.
Тайлал
Төгсгөл	Саран хөхөө тэнгэрийн оронд дэвшсэн буюу 9-р бүлэг

Алхам 2.

Жүжгийн зарим үйл явдал хаана хаана өрнөж байгааг гүйцээн бичээрэй.

Хаана?	Ямар үйл явдал болдог вэ?
Энэтхэгийн өрнө зүгийн Хачийн орны Цаландара балгасанд	Мадимахани төрж өснө.
Варнаси
Удаяна хот	Номунбаясгалан, Лагана нарт увдис заасан Тарва бярмань ирсэн газар буюу Ариун таван орны нэг.
Махазана мөрөн

Алхам 3. Жүжгийн үйл явдалд гарч байгаа цагийн утгыг нөхөж гүйцээнэ үү.

Хэзээ?	Ямар үйл явдал өрнөсөн бэ?
Номунбаясгаланнасандаа ямар үйлд суралцсан бэ?	Тарва бярман хүүрт орох увдис заана.
Номунбаясгалангийн 13 настайд
<u>Олон хоног</u> номын хуримд цэнгэсэн	Саран хөхөө болсон Номунбаясгалан нэгэн шөнийн дотор зовж шаналан их зүйлийг ухаарч, маргааш нь Хувилгаан хөхөөтэй учирснаар

Дууссан:онсарөдөр

Сурагчийн нэр: Эхэлсэн: он сар өдөр

Өөрийн үнэлгээ 1. Зохиолын бодит ба хийсвэр дүр нь утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах чадвараа үнэлье.

Чадвар	Шалгуур	Мэддэг байсан	Улам хөгжүүлсэн	Шинээр сурсан
Зохиолын бодит ба хийсвэр дүр нь утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах	Бодитой бус санаа сэтгэлийн хий(биегүй) дүрийг хийсвэр дүр гэдгийг мэднэ.			
	Хийсвэр дүр бодит амьдрал дээр байдаг ямар нэг санаалаг шинж чанартай юм, үзэгдэл, хүнээс ихээхэн холдож, саармагжсан оюун санааны дүр байдгийг мэднэ.			
	Хийсвэр дүр нь өвөрмөц шинжээрээ бодит байдлыг төлөөлөх чадвартайг мэднэ.			
	Уран зохиолд өөрсдөө үзэж хараагүй зохиомол баатар хийгээд уран сэтгэмжийн тусламжтай бүтээсэн өвөрмөц, хачирхмаар сонин гаж дүрийг өргөн ашигладгийг мэднэ.			
	Бодит байдлаас холдсон ийм төрлийн зохиомол дүрийг ерөнхийд нь болзолт дүр гэдгийг мэднэ. Жишээ нь: Луу, гарьд, там, бирд, чөтгөр гэх мэт			

Өөрийн үнэлгээ 2

Чадвар	Шалгуур	Мэддэг байсан	Улам хөгжүүлсэн	Шинээр сурсан
Зохиолын өгүүлэгдэхүүний бүтцийг тайлбарлах	Зохиолын өгүүлэгдэхүүний чухал бүрдэл болох зангилаа нь тухайн зохиолын ерөнхий гол зөрчил байдгийг мэднэ.			
	Жүжгийн зохиолд үндсэн болон түүнээс салж салбарласан, угсарсан олон тооны зөрчлүүд үүсдэгийг мэднэ.			
	Зөрчлүүд нь зохиолын дүрийг хэрэг явдалд татан оролцуулж, үйл явдлыг эрчимжүүлдгийг мэднэ.			

Дууссан:онсарөдөр